

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

*Б. Мөнхжаргал  
Магистрант*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн ахисан түвшний сургууль*

*tuulii8802@gmail.com*

*Я. Төгөлдөр  
Доктор (Ph. D.), дэд профессор*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

*tugul@must.edu.mn*

**Хураангуй.** Төрийн албыг хөгжүүлэхэд тулгамдаж буй олон асуудал байгаа бөгөөд өөрчлөлт, шинэчлэл хийх, ёс зүйн хариуцлагын хэрэгжилтийг боловсронгуй болгох хүлээлт нийгэмд бий болоод багагүй хугацаа өнгөрч байна. Өнөө цагт мэргэшсэн тогтвортой төрийн алба, түүний хараат бус байдал, төрийн албаны стандарт, төрийн албаны ёс зүй, төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй болгох гэх мэт тулгамдсан асуудлууд шийдлээ хүлээсээр байна. Монгол Улсын үндсэн хууль болон Төрийн албаны тухай, Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх Монгол Улсын хууль, Төрийн захиргааны албан хаагчийн ёс дүрэм зэрэг төрийн албан хаагчийн ажиллах үндсэн зарчим, эрх үүрэг, ёс зүйн талаар заасан байдаг. Энэхүү судалгааны хүрээнд Өмнөговь аймгийн төрийн байгууллагын ёс зүйн хариуцлагын хэрэгжилтийг баримт бичгийн болон ярилцлагын аргаар судласан болно.

**Түлхүүр үгс:** Албан хаагчид, төрийн захиргааны, тулгамдсан асуудал, ёс зүйн зөрчил, зохицуулалт, хэрэгжилт

## УДИРТГАЛ

Ёс зүй бол хүний тухай шинжлэх ухаан юм, тэрээр “Хүнд юуг хийх, юунаас татгалзах хэрэгтэйг танихад тусалдаг зүйл бол ёс зүй юм” мөн “ Төрийн засаглалыг ёс зүй, улс төрийн хувьд шалгарсан мэргэжлийн хүмүүс хэрэгжүүлнэ” гэж суут сэтгэгч Аристотел хэлсэн бөгөөд энэ нь төрийн алба мэргэшсэн

тогтвортой, түүний албан хаагч ёс зүйтэй байхыг тодорхойлжээ. Учир нь, төрийн албан хаагчдын ёс зүйн нийгэмд олон үнэт зүйлсийг бий болгоход тусална. Иймд төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлага гэдэг бол тэдний үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор

тавигддаг ёс зүйн шаардлагуудыг ухамсарлан мөрдөх явдал бөгөөд төрийн албан хаагчийн зан үйлийн

ёс журам нь ухамсартай сахилгад үндэслэгдэнэ. Төрийн албан хаагчдын эрх, үүргийг хуулиар тогтоохын зэрэгцээ юуг хийх, юунаас татгалзахыг ёс зүйн дүрмээр тодорхойлдог. Ёс зүйн дүрэм үйлчилж буй хэдий ч практикаас үүдэлтэй ёс зүйн зөрчил, маргааныг сайтар боловсруулсан хэм хэмжээ, механизм үгүүлэгдэж байна.

Ийнхүү төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлагын хэрэгжилтийн асуудлыг хөндөхдөө тэдгээрийн эрх зүйн орчин болон хууль дээдлэх ёсны шаардлагыг хэрхэн биелүүлж байгааг тодорхой судалгаанд тулгуурлан авч үзсэн болно.

## **ОНОЛЫН ТОЙМ СУДАЛГАА**

Аливаа нийгэмд нэг ижил агуулгатай ёс суртахуун үйлчлэх нь чухал байдаг ба ёс суртахуун нь нийгмийн давхаргыг ялгаварлахгүйгээр бүхий л давхаргад ижил үйлчилдэг юм. Тухайн нийгмийн зорилтоос үндэслэж ёс суртахууны хэм хэмжээ, үнэлэмж баяжин хөгжиж боловсронгуй болсоор иржээ. Монгол улсын төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой харилцааг “Монгол улсын Үндсэн хууль”, “Монгол улсын Төрийн албаны тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”, “Монгол улсын Их Хурлын дэгийн тухай хууль”, “Монгол улсын Их Хурлын гишүүний эрх

зүйн байдлын тухай хууль”, “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль” болон “Монгол улсын захиргааны албан тушаалтны ёс зүйн дүрэм”, “Монгол улсын шүүхийн ёс зүйн дүрэм”, “Цагдаа, Прокурорын сахилгын дүрэм” зэрэг хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулж байна.Төрийн алба нь өргөн утгаараа төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага, төрийн өмч бүхий байгууллага, албан газар, улсын үйлдвэрийн газрын захиргаанд явагдах үйл ажиллагаа байдаг бол явцуу утгаар нь засаглан захирах шинжийг агуулсан төрийн эрх мэдлийн байгууллагын хүрээн дахь ажиллагаа гэж үзэх нь бий.

Монгол Улсын өнөөгийн мөрдөж буй Төрийн албаны хууль[1]-д “Төрийн зорилт чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ” хэмээн тодорхойлсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт “ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн албаны үндсэн зарчим мөн” гэж заажээ.Төрийн албанд “захирах захирагдах ёс, ил тод байх, ард түмэнд үйлчлэх, иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх, төрийн алба мэргэшсэн тогтвортой байх, төрийн

албан хаагчаас бүрэн эрхээхэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах..." гэсэн тусгай зарчмыг баримталдаг.

Төрийн ямар зорилт чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж байгааг нь үндэслэн:

- төрийн улс төрийн алба
- төрийн захиргааны алба
- төрийн тусгай алба
- төрийн үйлчилгээний алба гэж ангилна.

Тухайн төрийн албаны хүрээнд төрийн тодорхой зорилт чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулахаар Монгол улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан журмаар байгуулсан байгууллагыг төрийн байгууллага гэнэ.[2]

Тухайн төрийн байгууллагын өмнө дэвшүүлсэн төрийн зорилт чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг явуулахын тулд зохион байгуулалтын бүтцэд эрх үүргийн нэгдэл бүхий анхан шатны нэгж буюу албан тушаал бий болдог байна. Төрийн алба, түүний салбар, төрөл тус бүрээр төрийн албан тушаалын ангилал зэрэглэлийг тогтоосон байна. Төрийн албан тушаалын ангиллын тогтолцоо нь төрийн байгууллагын удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилах нөхцлийг бүрдүүлж байдаг. Төрийн албан тушаал нь удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлтэй байдаг.[3]

Төрийн албан тушаалд тавигдах ерөнхий шаардлагыг хангасан Монгол улсын иргэн төрийн албанд орж ажиллах эрхтэй. Төрийн албан тушаалд тодорхой шаардлага тавьж байгаа нь төрийн зорилт чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх төрийн албан хаагчийг зохих журмын дагуу шилж сонгох нөхцлийг бүрдүүлэх юм. Төрийн албан тушаал /ажлын байр/-д тавих шаардлагыг хангасан иргэнийг холбогдох хууль тогтоомжид заасан журмаар сонгууль, томилолт, төрийн албаны мэргэшлийн шалгалт, эсвэл хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулснаар эрх зүйн харилцаа үүсэх ба төрийн албан хаагч бүрэн эрхийнхээ дагуу төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулна. Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ёсоор төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ[4].

Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 2, 3-т заасан албан тушаал /төрийн захиргааны албан тушаал болон төрийн тусгай албан тушаал/-ын ангилалын хүрээнд төрийн удирдах, гүйцэтгэх, албан тушаалыг мэргэшлийн үндсэн дээр байнга эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг төрийн жинхэнэ албан хаагч гэдэг.[5]

Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой Төрийн албаны тухай хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийг үндэслэн зохицуулдаг байна. Төрийн захиргааны албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт заасан хариуцлагатай албан тушаал эрхэлж, Монгол Улсын хууль, төрийн бодлого, Засгийн газрын тэргүүлэх чиглэл, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн бодлогын уламжлал, шинэчлэлийг хангах, төрийн байгууллага, төрийн өндөр албан тушаал эрхэлдэг албан хаагчийг мэргэшлийн өндөр түвшний зөвлөлгөө, бүх талын дэмжлэг, үйлчилгээгээр хангах замаар төрийн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааных нь үр дүнг дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг ард түмэнд хүргэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна. Төрийн албан хаагч нь төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх талаар бусад ангилалын албан тушаалын албан хаагчдаас илүү өндөр үүрэг хариуцлагыг хүлээж байдаг учир нийгмийн баталгааны хувьд илүү хөнгөлөлт хамгаалалттай байхыг төрийн албаны тухай хуулиар баталгаажуулсан байна. Төрийн албан хаагчийн ёс суртахуунгүй байдал нь олон түмний анхаарлыг маш их татаж улс төрийн шинж аясыг агуулсан сэдэв рүү орох нь ч ажиглагдаж байдаг. Энэ нөхцөл

байдал нь төрийн албыг мэргэжлийн үйл ажиллагаагаараа хангаж, төрийн бодлогыг хэрэгжүүлж байдаг төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлагын хэм хэмжээг улам нарийн боловсруулж мөрдөх шаардлагатай байгааг илэрхийлж байна.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ


### *Судалгааны зорилго.* Ёс

зүйн хариуцлагын талаарх онол, арга зүйг судалж Өмнөговь аймгийн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын ёс зүйн хариуцлагын хэрэгжилтийг баримт бичгийн аргаар шинжлэн өнөөгийн байдлыг тодорхойлохыг зорисон болно.

Төр нь ард түмний сайн сайхан амьдрал, хөгжил дэвшлийг хангахын төлөө үйл ажиллагаа явуулж түүнийгээ өдөр тутам удирдан зохион байгуулах үүргийг нийгмийн өмнө хүлээж байдаг.

Төрийн албанд ажиллагчид 2019 оны байдлаар нийт 3759, Захиргааны албаны ажиллагчид 250, Тусгай албаны ажиллагчид 500, Үйлчилгээний албаны ажиллагчид 3009 байна.

Зураг 1. Өмнөговь аймгийн Төрийн нийт албан хаагчдын тоо



(Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний статистик мэдээ, 2019)

2019 оны байдлаар 3759 Төрийн албан хаагч байгаа бөгөөд

тэдгээрийн нэлээд нь өмнө нь батлагдсан сул орон тоонд томилогдсон бол үлдсэн нь шинээр байгуулагдсан байгууллагын болон урд өмнөх байгууллагын нэмэгдэж батлагдсан орон тоонд томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчид юм. Бусад нь төрийн тусгай албаны ангиллын албан хаагчид байгаа бөгөөд харин улс төрийн албан хаагчдын тоонд өөрчлөлт гараагүй байна.


Зураг 3.2.Төрийн албан хаагчдын хүйсийн харьцаа



(Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний статистик мэдээ, 2019)

Өмнөговь аймгийн төрийн албан хаагчдыг хүйсээр нь харьцуулж үзэхэд эрэгтэй- 1129, эмэгтэй -2630 албан хаагчид ажиллаж байна. Үүнээс үзэхэд тус аймгийн төрийн албанд дийлэнх нь эмэгтэй албан хаагчид байгааг харуулж байна. Монгол Улсын хэмжээнд эмэгтэй Төрийн албан хаагчийн тоо жил ирэх тусам өсөх хандлагатай байна.


Зураг 3.3. Төрийн албан хаагчдын насны ангилал



(Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний статистик мэдээ, 2019)

Өмнөговь аймгийн төрийн албанд ажиллаж буй албан хаагчдын насны ангиллыг харьцуулж үзэхэд 20 хүртэлх насны 16, 21-25 насны 364, 26-30 насны 661, 31-35 насны 738, 36-40 насны 481, 41-45 насны 422, 46-50 насны 460, 51-55 насны 383, 56-60 насны 184, 60-аас дээш насны 40 албан хаагчид тус тус ажиллаж байна. Үүнээс дүгнэж үзэхэд 31-35 насны албан хаагчид дийлэнх буюу 738 албан хаагчид байгааг харуулж байна.

Зураг 3.4. Өмнөговь аймгийн төрийн албан хаагчдын боловсролын түвшин




(Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний статистик мэдээ, 2019)

Өмнөговь аймгийн төрийн албан хаагчдын боловсролын түвшинг харьцуулж үзэхэд доктор-6, магистр- 173, бакалавр -2069, дипломын дээд боловсролтой-76, тусгай дунд 572, бүрэн дунд 487, бүрэн бус дунд 289, бага боловсролтой 65, боловсролгүй 12 албан хаагч ажиллаж байна. Үүнээс дүгнэж үзэхэд төрийн

албан хаагчдын дийлэнх буюу 2069 албан хаагчид бакалаврын боловсролтой байна.


Зураг 3.5. Төрийн захиргааны албан хаагчид, албан тушаалын ангиллаар



(Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний статистик мэдээ, 2019)

Өмнөговь аймгийн захиргааны албан хаагчдыг албан тушаалаар нь харьцуулж үзэхэд эрэгтэй тэргүүн түшмэл 74 байгаа бол эмэгтэй нь 28 байна. Мөн эрхэлсэн дэд түшмэлээс эрэгтэй 109, эмэгтэй 50 албан хаагч байна.


Зураг 3.6. Төрийн захиргааны албан хаагчдын бүрэлдэхүүн



(Эх сурвалж: Өмнөговь аймгийн Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний статистик мэдээ, 2019)

Төрийн захиргааны албан хаагчдын бүрэлдэхүүнийг судалж үзэхэд нутгийн захиргааны байгууллага болон түүний харьяа байгууллагууд 189, төрийн захиргааны байгууллага түүний харьяа байгууллагад 310, төрийн захиргааны төв байгууллага түүний харьяа байгууллага 751 албан хаагчид ажиллаж байна.

Зураг 3.7. Төрийн үйлчилгээний албан хаагчдын төрөл



Өмнөговь аймгийн төрийн үйлчилгээний албан хаагчдын төрлийг харьцуулж үзэхэд гүйцэтгэх албан хаагчид -1667, туслах албан хаагчид- 1021, удирдах албан хаагчид-321 тус тус эзэлж байна.

Монгол улсын хэмжээнд/аймаг, нийслэл, яам, агентлаг/ 2019 оны байдлаар Төрийн захиргааны 316, Төрийн үйлчилгээний 321 албан хаагч нийт 637 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан байна. Үүнээс 17 зөрчлийг төрийн захиргааны удирдах албан тушаалтан, 299 зөрчлийг төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалтан, 321 зөрчлийг төрийн үйлчилгээний байгууллагын албан хаагч гаргасан байна. Энэхүү зөрчил гарч буй үндсэн шалтгаан нь хүнд суртал, харилцааны доголдол, ур чадварын дутмаг байдал байна гэж Удирдлагын академиас гаргасан судалгаан дээр дүгнэсэн байна.

(Эх сурвалж: [www/csc.gov.mn](http://www/csc.gov.mn))

2011 оноос хойш төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг авч үзэхэд 2011-2013 оны хооронд зөрчлийн тоо тогтмол буурч байгаад 2014 онд 118-347 болж огцом өссөн байна. Харин 2015-2016 онд мөн адил 347-193 болтлоо буурсан бол 2017-2019 оны

хооронд 334-316-н зөрчил илэрсэн байна.

**Өмнөговь аймгийн Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн статистик:**

Төрийн албаны нэр хүнд нь төрийн албан хаагчийн ёс зүй, зан үйлийн хандлагатай холбоотой тул төрийн албаны нэр хүндийг ямагт эрхэмлэж, төрд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх нь төрийн албан хаагч бүрийн үүрэг болохын хувьд төрийн захиргааны, төрийн үйлчилгээний, төрийн тусгай албаны болон төрийн улс төрийн албан хаагч нар “албан хаагч нэг бүрийн үүрэг” гэж үзэн төрийн албанд ёс зүйн хэм хэмжээг сахиулахад хяналт тавьж ажиллах зайлшгүй шаардлагатай байгаа юм. Төрийн албаны зөвлөл Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”, 2019 оны 33 дугаар тогтоолоор батлуулсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д заасны дагуу төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг Өмнөговь аймгийн хэмжээнд 2019 оны бүтэн жилийн байдлаар нэгтгэн судалсан болно. Үүнд:

-Төрийн захиргааны удирдах албан тушаалтантай холбоотой-0,  
 -Төрийн захиргааны гүйцэтгэх албан хаагчтай холбоотой 14  
 -Төрийн үйлчилгээний албан хаагчтай холбоотой 9 ёс зүйн зөрчил бүртгэгдсэн байгаа нь өмнөх оныхтой харьцуулахад 5.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Ёс зүйн зөрчлийг хүлээн авсан үндэслэл, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн зэрэг дэлгэрэнгүй байдлаар дараах хүснэгтээр нэгтгэн гаргасан.

Хүснэгт 3.1. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн байдал

Хүлээн авсан үндэслэл		Зөрчлийг анх буюу давтан үйлдсэн аль нь болох		Хэрхэн шийдвэрлэсэн тухай								
Журам 1.2	Журын 2.2.5	Ёс зүйн хорооны дүгээлтийг	Томилгох эрх бүхий албан тушаалтна шийдвэр									
Гомдлоор	Мэдээлээ р	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мөрөөр	Ёс зүйн хороо өөрийн санаачлагаар	Байгууллагын удирдлагын шийдвэрээр	Анх	Давтан	зөвшөөрсө н	зөвшөөрөөгүй	TATX-ийн 26.1.1	TATX-ийн 26.1.2	TATX-ийн 26.1.3	Сахиулан шийтгэл ногдуулах шаардлагагүй гэж үзсэн
4	-	2	3	10	19	4	15	8	9	14	0	0
				23	23	23						
<b>Нийт 23 ёс зүйн зөрчил</b>												

Дээрх хүснэгтээс харахад Өмнөговь аймгийн төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн талаарх иргэдийн гомдол, мэдээллийг үндэслэн ёс зүйн хороо авч хэлэлцсэн тохиолдол 4 байхад

байгууллагын удирдлагын санаачлага, шийдвэрээр ёс зүйн зөрчлийг авч хэлэлцсэн тохиолдол 10 байна.

Харин ёс зүйн хороод хэвлэл мэдээллийн хэрэгслийн баримтат мэдээлэл болон өөрийн санаачлагаар төрийн албан хаагчийн ёс зүйн үйлдлийг авч хэлэлцсэн тохиолдол харьцангуй цөөн байна. Энэ нь ёс зүйн хороод өөрийн санаачлагатай, идэвхитэй ажиллах байдал сулавтар байгааг харуулж байна. Ёс зүйн зөрчлийг анх удаа гаргасан 19 албан хаагч байгаа бол давтан гаргасан 4 албан хаагч байгаагаас Ёс зүйн хорооны дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн 15, хүлээн зөвшөөрөөгүй 8 албан хаагч байна.

Ёс зүйн хороодын дээрх шийдвэрээр төрийн албан хаагчдад ногдуулсан сахилгын шийтгэлийг төрлөөр авч үзвэл:

-9 албан хаагчид-сануулах /ТАТХ-ийн 26.1.1/,

-14 албан хаагчид-албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах /ТАТХ-ийн 26.1.2/.

Төрийн албаны тухай хуульд төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно гэж заасан тул Төрийн албаны зөвлөлөөс “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн төслийг шинээр

боловсруулж, Засгийн газарт хүргүүлж батлуулсан байна. Уг дүрмээр төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн харилцааг зохицуулахаас гадна ёс зүйн зөрчилд зөвхөн ёс зүйн хариуцлага хүлээлгэх талаар тусгагдсанаараа онцлог юм.

Эндээс харахад материаллаг /цалин бууруулах/ болон ёс зүйн /сануулах/ шийтгэл зонхилж байгаа нь харагдана.

Өмнөговь аймгийн Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн тухай сүүлийн 5 жилийн байдлыг харьцуулан үзэхэд өнгөрөгч 2019 онд бүртгэгдэж ёс зүйн хороодоор хэлэлцэгдсэн зөрчлийн тоо өмнөх 2 жилийн буюу 2017 оны дүнгээс 19 буюу 8.9 хувиар буурсан байв.

### **ДҮГНЭЛТ**

Төрийн албан хаагчдын ёс зүйн хариуцлагын хэрэгжилтийн талаар авсан дийлэнх судалгааны дүгнэлт нь төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээгээ зөрчдөг хэмээн гарсан байдаг. Чухам юунаас болж төрийн албан хаагчид нь ёс зүйгээ сахиж чадахгүй байна гэдгийг төрийн албан хаагчийн талаас судалж үзсэн юм.

Энэ судалгааны дүнгээс үзвэл төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ёстой, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж байх ёстой төрийн өндөр албан тушаалтнууд, шууд харъяалан удирдлагаар хангах эрх бүхий албан тушаалтнууд, улс төрийн албан тушаалтнууд өөрсдөө энэ

зөрчлийг гаргах нөхцлийг бүрдүүлдэг болох нь тодорхой харагдаж байгаа юм.

Үүнээс болж төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд хяналт байхгүй болж төрийн үйл ажиллагаа бүхэлдээ хямрах, ард иргэд үйлчилүүлэгчид төрдөө итгэх итгэлгүй болж байгаа дүр зураг ажиглагдаж байна.

Мөн төрийн албан хаагчдын идэвхгүй байдал ч ёс зүйн зөрчилд нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл хууль, дүрмийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх ёстой, түүнийг сурталчлах ажлыг зохион байгуулах нийтлэг үүрэгтэй төрийн албан хаагчид маань өөрсдөө төрийн албан хаагчийнхаа ёс зүйн дүрмийг батлагдаад 5 сарын хугацаа өнгөрч байхад хэрэгжүүлж ажиллах нь бүү хэл өөрсдөө \судалгаанд оролцогчдын 59,1 хувь \уншиж судлаагүй байдалтай байгаа нь харамсалтай байгаа юм.

Энэ нь төрийн албыг иргэн сонгож ажилд орохдоо улс орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө гэсэн сэтгэлээр бус зөвхөн тогтвортой цалинтай байж, хувийн ашиг сонирхолыг хэрэгжүүлэхийн тулд сонгож байгаатай холбоотой юм. Нөгөө талаар төрийн аль ч байгууллагад шинээр ажилд орж байгаа иргэдэд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах наад захын дүрэм журмуудыг уншуулж танилцуулдаггүй зөвхөн хийх ажилтай нь холбоотой ажлын байрны тодорхойлолтыг нь хүлээлгэж өгдөгтэй холбоотой юм.

Ёс зүйн хариуцлага гэдэг бол гүнзгий утгатай, өргөн цар хүрээтэй ойлголт учраас ёс зүйнзөрчлийг бууруулах ажлыг зохион байгуулахдаа цогц байдлаар зохион байгуулахгүй бол зөвхөн орчны хүчин зүйлүүдийг харгалзан үзсэнээр эсвэл цалин хөлсийг нэмснээр ч юм уу, сургалт зохион байгуулж хариуцлагыг чангатгаснаар энэ асуудал шийдэгдэх боломжгүй юм.

Тийм учраас төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг сайжруулах, төрийн албанд шудрага байдлыг бий болгох, ёс зүйн хариуцлагын хэрэгжилтийг сайжруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж бодож байна.

-Сурагч ахуй цагаас нь төрийн албанд орох сонирхолтой хүүхдүүдэд ёс зүйн хуудас хөтөлдөг байх, иргэнийг төрийн албанд анх ороход нь энэ хуудсыг нь ёс зүйн үндсэн шалгуур болгон ашигладаг байх

-Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хуваарьт ёс зүй, хувь хүний үнэт зүйл, эрхэмлэндээдлэх зүйлсийн талаар таниулах хичээл оруулах

-Шинээр ажилд орж буй ажилтнуудад төрийн байгууллагын үнэт зүйл, ёс зүйн дүрмийг танилцуулж зөвлөгөө өгөх, төрийн албан хаагчдад ёс зүйн дүрмийн заалт бүрийг ямар утгатайг, өөрийнх нь хашиж буй албан

тушаалынхувьд ямар уялдаа холбоотойг ойлгуулах,

-Төрийн албаны зөвлөлөөс ёс зүйн гарын авлага материалыг төрийн байгууллагуудад тогтмол хүргүүлж байх, богино хугацааны сургалтуудыг тогтмол зохион байгуулж байх

-Байгууллагын дарга нар болон энэ асуудлыг хариуцахаар томилогдсон ажилтнуудад зөвлөгөө өгч, ёс зүйн талаарх хууль, дүрмийг тайлбарлаж, сурталчилж байх

-Хяналтын хамгийн бие даасан, хөндлөнгийн нөлөөнөөс хамгийн бага хамааралтай, харьцангуй үр ашигтай, шударга хэлбэр нь ард олны буюу үйлчлүүлэгчдийн зүгээс тавигдах хяналт байдаг учраас төрийн албан хаагч нарын ёс зүйн хэм хэмжээнд иргэдийн тавих хяналтыг төрийн албаны тухай хуульд тусгаж өгөх

-Төрийн албан хаагч нарын цалинг амьдралын хэрэгцээгээ бүрэн хангах хэмжээнд хүргэж өгөх

-Ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагч нарт тухай бүр нь хариуцлага тооцож, зохисгүй үйлдлийг нь нийтэд мэдээлдэг сэрэмжлүүлдэг болгох зэрэг ажлуудыг зохион байгуулах нь зөв гэж үзэж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд дүрэм, журам, хууль тогтоомжийг чангатгахаас илүүтэйгээр төрийн албан хаагчид маань өөрсдөө ёс суртахуунтай, төрийн төлөө гэсэн сэтгэлээр үнэнч шударгаар ажиллах сэтгэл зүйг өөртөө

суулгаснаар төрийн албаны нэр хүнд унах явдлаас ангижирч, иргэд төрдөө итгэх итгэл сэргэж төрийн албаны ёс зүйн зөрчил буурах болно.

### НОМ ЗҮЙ

1. Монгол улсын Төрийн албаны тухай хууль-Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2002
2. Удвал В. *Төрийн албаны талаарх хууль эрх зүйн эмхэтгэл.* УБ., 2013
3. Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дугаар хэсэг
4. Монгол улсын Төрийн албаны тухай хууль-Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2002
5. Энхбаяр Б Төрийн албан хаагчийн ёс зүй., УБ., 2003
6. Монгол улсын Их сургууль “Төрийн албан хаагчийн ширээний ном” УБ., 2018
7. ШУТИС “Төрийн удирдлага” УБ., 2019
8. [www.legalonfo.mn](http://www.legalonfo.mn)
9. [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn)
10. [www.open-government.mn](http://www.open-government.mn)
11. [www.omnogovi.gov.mn](http://www.omnogovi.gov.mn)